

“Төгс аялгуут” нийгэмд үйлчлэгч төрийн бус байгууллага нь 2013 онд (**Улсын бүртгэлийн** 0871001018 дугаар, **регистрийн дугаар** 8095698, цахим хаяг: (**page**) Төгс-Аялгуут, **Утас:**94073939) байгуулагдсан бөгөөд хүүхэд гэр бүлд хууль эрх зүйн мэдлэг олгох, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг билээ.

Бид Дундговь аймгийн иргэддээ зориулан “Аялгуут нутаг” сэтгүүлийг эрхлэн гаргаад нэг жил болсон байна. Мөн 2019 оны 11 сарын 1-ны өдрөөс эхлэн KINGNEWS.MN Сайтаар дамжуулан орон нутгийн мэдээ мэдээллийг дэлхийн өнцөг булан бүрт хүргэн ажиллаж байна.

Мөн манай байгууллага Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.6, 9.7, 9.8-д төрийн захиргааны байгууллага жил бүр Хэрэглэгчийн үнэлгээг хийлгэсэн байна гэсэн заалтыг үндэслэн. Тухайн байгууллагаас иргэдэд хүргэж буй үйлчилгээний чанар, хүртээмж, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судлуулж, түүнд дүн шинжилгээ хийлгэн цаашдын үйл ажиллагаагаа төлөвлөх, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа авах ажлыг 2017 оноос эхлэн орон нутагт зохион байгуулж ирсэн ба одоогоор Хүнс хөдөө аж ахуйн газар, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар зэрэг байгууллагуудын хэрэглэгчийн үнэлгээг 2017, 2018 онуудад хийж гүйцэтгэн, зөвлөмж боловсруулан ажиллаж байна.

Мөн өнгөрөгч 2019 онд аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар, Хүүхэд гэр бүл залуучуудын хөгжлийн газар, Татварын хэлтэс, Стандарт хэмжил зүйн хэлтэс гэсэн 4 байгууллагын хэрэглэгчийн үнэлгээг хийсэн бол Дэрэн, Гурвансайхан, Цагаандэлгэр сумдын хэрэглэгчдийн үнэлгээг мөн хийгээд байна.